



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/92

Алтай хот

**“Туульсын хаан Жангар” арга хэмжээнд
хөрөнгө гаргах тухай”**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10,11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу Юнеско-д 2009 онд бүртгэгдсэн Монгол тууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв болох Монгол Жангар хайлах өвийг хамгаалах, сурталчлах, өвлүүлэх, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй “Туульсын хаан Жангар” арга хэмжээний заалны зохион байгуулалтын зардалд шаардагдах 8,274,800 (найман сая хоёр зуун далан дөрвөн мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж “Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв” НУТҮГ-т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг “Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв” НУТҮГ (Т.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилт, ажлын чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (П.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс(С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2013 оны
02 дугаар сарын 10 ны өдрийн 43 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Төрөл	Нэр	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз, дэлгэц Хулдаасан хэвлэлт	Жангар хэвлэлт	17.5 м2	2	14,000	490,000
2		Баннер	6.5 м2	2	14,000	182,000
3		Прүүс	2*3м	19	65,000	1,235,000
		Дэлгэц	3*2м	1	1,300,000	1,300,000
4		Дэлгэцний доод хэвлэлт	1.8 м	1	14,000	25,200
5		Үүл хэвлэлт	67.5 м	1	14,000	945,000
6	Гэр хэлбэрт оруулах	Тооно	Алтай чуулга			
		Хана				
		Унь хийх даавуу	15м*1м	8	8,500	1,020,000
7	Гадна хаалга	Гадна үүдний хэвлэлт	27м	2	14,000	756,000
8		Нүүр	9 м2	2	35,000	630,000
9		Хаалганы дээд тал	12 м2	1	35,000	420,000
10	Урилга	Хэвлэлт		100	5,000	500,000
11	Аннос	Хаяг, тайлбар хэвлэх	6 м2	-	12,000	72,000
12	Өнгөт хор	Хоргонд байрлуулах	4	-	7,000	28,000
13	Батерейгаар ажиллах гэрэл	Хаяг тайлбар бүрэх	10	-	10,000	100,000
15	Ламинаторын цаас	Мэдээлэл хэвлэх	1	-	30,000	30,000
16	Бичгийн цаас	Хаяг, тайлбар хэвлэх	1	-	20,000	20,000
17	Фото цаас		1	-	20,000	20,000
18	Тээврийн хөлс	-	-	-	501,600	501,600
Нийт дүн						8,274,800